

ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагчийн нэр: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын Тамгын газар
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын нэр: Техник эдийн засгийн үндэслэл зураг төсөв боловсруулах
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: БХАЖИСЗДТГ/20260201009
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: “Багцтай” 1. Нийтийн ариун цэврийн байгууламжийн зураг төсөв 2. Эрүүл мэндийн төвийн барилгын засварын зураг төсөв 3. Хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв 4. Хөнөг 3-р багийн төвийн спорт заалны зураг төсөв
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтын урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 1.5	Үйлчилгээний үр дүнд оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний этгээд эзэмших эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр: Сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 48,000,000 /Дөчин найман сая/ төгрөг
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 1 давхарт 103 тоот Утасны дугаар: 98086655 Хүлээн авагчийн нэр: Н.Эрдмаа Үнэлгээний хорооны нарийн бичиг Цахим шуудангийн хаяг: n.erdmaa12@gmail.com
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 11.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэлийг ТШЗ 11.1-д зааснаас өөрөөр заах бол: Монгол хэл
ТШЗ 14.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 15.2	Ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой хуулийн 15.2-т зааснаас бусад нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм” 1. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. 2. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.

	2. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаархи хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ. 3. Улсын бүртгэлийн гэрчилгээг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй, "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем" (www.tender.gov.mn)-ээр дамжуулан шалгана. 4. Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл ирүүлэх. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргагцтай байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: "Шаардана" • Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу эх загвар зургийг холбогдох норм стандартын дагуу хийж ирүүлнэ. • Бага хугацаанд түргэн шуурхай гүйцэтгэвэл давуу тал болно. • Борлуулалтын орлогын хэмжээ 2024, 2025 он тус бүр борлуулалтын орлого нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна. • Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ. • Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. • Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. • Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай.
ТШЗ 16.2	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж шаардах эсэх, шалгалт туршилт зохион байгуулах эсэх: "Үгүй"

ТШЗ 18.1	1.Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана” Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг сангийн яамны санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Санал болгож байгаа үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна. - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд: - Байгууллагын харилцагч банк дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна. - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж, зээл олгох боломжтой гэсэн утга бүхий мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй/ - Харилцагч банк тус бүрээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ. - Дээрх тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна. Тендерт оролцогч нь 2024, 2025 онд ашигтай ажилласан байхыг анхаарна уу.
----------	---

ТШЗ 19.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана” Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих жилийн тоо 2024, 2025 оны аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 70 хувиас багагүй үнийн дүнтэй тэнцэх зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн байх. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Туйм” Ижил төстэй ажилд тооцуулахаар ирүүлсэн ажлын гүйцэтгэсэн гэрээ, Загвар зураг, Нүүр хуулбарыг ирүүлнэ. Тухайн орон нутагт ажил гүйцэтгэж байгаа бол давуу тал болно. Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн одоо гүйцэтгэж байгаа дуусаагүй ажлын гүйцэтгэл нь 70 хувиас багагүй байх шаардлагатай бөгөөд ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 4-ийн дагуу ирүүлнэ. Ижил төстэй давхар гэрээт ажил 3 аас их бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Аль нэг баримтыг ирүүлээгүй бол тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.
-----------------	---

ТШЗ 19.2 Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ.

№	Албан тушаал	Тоо	Мэргэжил, боловсрол	Ажилласан жил
1	Архитектор	1	Архитектор	Мэргэжлээрээ 3 буюу түүнээс дээш жил ажилласан
2	Халаалт агаар сэлгэлтийн инженер	1	Мэргэшсэн байх	Мэргэжлээрээ 3 буюу түүнээс дээш жил ажилласан
3	Ус хангамж ариутгах татуургын инженер	1	Мэргэшсэн байх	Мэргэжлээрээ 3 буюу түүнээс дээш жил ажилласан
4	Төсөвчин	1	Мэргэшсэн төсөвчин	Мэргэжлээрээ 3 буюу түүнээс дээш жил ажилласан

Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж цахим системээр ирүүлнэ. Оролцогчийн үндсэн ажилтан хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх 5 бүлэг заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.

Архитектор нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн гурван сар тендерт оролцогч аж ахуйн нэгж тасралтгүй төлсөн болохыг цахим системээс шалгана.

Оролцогчийн санал болгосон ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тухайн оролцогч төлдөггүй ажилтны хувьд хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай.

Хүснэгтэд байгаа инженер, техник болон мэргэжилтэй ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг цахим системээр ирүүлнэ.

Инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбар ирүүлнэ.

ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл: “Шаардана” ЗТ – 2.1 Барилга байгууламжийн архитектур орчны тохижилтын зураг төсөл ЗТ – 6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл. ЗТ – 6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем, гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл. ЗТ – 6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35кВт хүртлэх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл. ЗТ – 6.4 Барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын бусад дохиоллын системийн зураг төсөл, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл. ЗТ–10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байвал зохино. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь дээр дурдсан хугацааг хангаагүй буюу хүчингүй болсон тусгай зөвшөөрөл бүхий тендерээс татгалзана. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу. Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөл, гэрээтэй байна.
ТШЗ 20.3	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 23.1	Тендерийн баталгааны дүн: Шаардахгүй
Г.ТЕНД	ЕР ИЛГЭЭХ, ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ТЕНДЕР НЭЭХ
ТШЗ 23.5	Оролцогчдод ил болгох нэмэлт баримт бичгийн жагсаалт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22.6-д заасны дагуу оролцогч тендерийн баримт бичиг, мэдээллийг ил болгохыг зөвшөөрч илгээнэ
ТШЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут
ТШЗ 25.3	Үнийн санал дуудах ажиллагаа эхлэх, үргэлжлэх хугацаа: Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Цаг: 12 цаг 00 минутаас эхлүүлж, 14 цаг 00 минут хүртэл

ТШЗ 26.1	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Цаг: 12 цаг 00 минут
Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 27.3	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Санамж

Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах ажлын техникийн тодорхойлолт (ажлын даалгавар)-ыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь гүйцэтгүүлэх ажлыг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд гүйцэтгүүлэх ажлын шинж чанар, үр дүн, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгавал зохино.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Ажил гүйцэтгэчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
[Ажлын даалгаврыг хавсаргана уу.]

Зураг төсөл, загвар зураг

[Шаардлагатай бол ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.]

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно. Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгыг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Үе шатны ажлын хуваарь

[Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана.]

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягтуудын жагсаалт:

Маягт 1: Тендер илгээх	22
Маягт 2: Хүний нөөцийн мэдээлэл	23
Маягт 3: Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл	23
Маягт 4: Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл	23
Маягт 5: Хэрэгжүүлж буй, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	24
Маягт 6: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	24
Маягт 7: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт	24

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2026.04.08**
 Тендер шалгаруулалтын төрөл: **Ажил**
 Тендер шалгаруулалтын нэр: **Зураг төсөв ТЭЗҮ хийх**
 Тендер шалгаруулалтын дугаар: **БХАЖИСЗДТГ/20260201009**
 Нийт төсөвт өртөг: **48,000,000 /Дөчин найман сая/**
 Тендер шалгаруулалтын арга: **Харьцуулалт**

1. **Жинст сумын Засаг даргын Тамгын газар** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Туйм**

Багц № 1: Нийтийн ариун цэврийн байгууламжийн зураг төсөв
Багц № 2: Эрүүл мэндийн төсвийн барилгын засварын зураг төсөв
Багц № 3: Хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн зураг төсөв
Багц №4: Хөнөг 3 дугаар багийн Спорт заалны зураг төсөв
3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **Тоо заахгүй**
4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ журмын 34 дүгээр зүйлийн 34.2**
5. Үнийн санал дуудах ажиллагааг **[2026.04.14 12:00]**–т эхлүүлж, **[2026.04.14 14:00]** хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг **[2026.04.14 11:00]**–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2026.04.14 -ны өдрийн, [12:00]-т** нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Жинст сумын ЗДТГ 98086655 99132654

55

Батлав
ЗАСАГ ДАРГА Б.АЛТАНХУЯГ

НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026.04.06

Дугаар:

Жинст

1	Үндэслэл	• Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
2	Зорилго	Иргэдийн ая тухтай аялах, амрах нөхцөлийг бүрдүүлж, стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламжийг бий болгоход оршино.
3	Хугацаа	Нийтийн эзэмшлийн талбайд ариун цэврийн байгууламж барих ажлыг захиалагч, гүйцэтгэгч талуудын гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
4	Эх үүсвэр	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт
5	Байршил	Бодь 5 дугаар багийн нутаг дэвсгэрт
6	Байгууламжийн хэмжээ	Байгууламжийн хэмжээ өргөн 3м урт 13 метр өндөр 2,8 багагүй байх
7	Байгууламжийн гаднах хийцлэл	Төмөр карказтай байгууламж, сэндвичэн эсвэл хөнгөн блокон бүтэцтэй
8	Бие Засах газрын дотор зохион байгуулалт	1. Эмэгтэй явган суултууртай кабин 2 ш 2. Эмэгтэй хүүхдийн суултууртай кабин 1ш 3. Эрэгтэй явган суултууртай кабин 2ш 4. Эрэгтэй хүүхдийн суултууртай кабин 1ш 5. Эрэгтэй хөтөвч /шээлтүүр/ 2ш 6. Тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө 1ш 7. Гар угаалтуур /тольтой/ нийт 4ш /1 хүүхдийн/ 8. Тусгаарлагч хана, хаалга /кабин бүр 900*1500 см-ээс багагүй хэмжээтэй, тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө 1800*1500см-ээс багагүй талбайтай, тасалгаа тус бүр хаалгатай, хувцасны өлгүүр, хогийн сав, ариун цэврийн цаас тогтоогч
9	Нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага	1. Нийтийн ариун цэврийн байгууламж нь жилийн дөрвөн улиралд ажилладаг, шингээх цооног байгууламжтай байх; 2. Нийтийн ариун цэврийн байгууламж барих байршилд гүний худаг гаргах эсвэл хамгийн ойр худгийн эх үүсвэрээс шийдэх 3. Байгууламжийн хийц нь цементэн суурьтай, хоорондоо бэхлэгдсэн байх 4. Нийтийн ариун цэврийн байгууламж нь явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замтай байх 5. Эрэгтэй эмэгтэй орох хэсгийг тусгаарлаж, тэмдэгжүүлсэн байх 6. Нийтийн бие засах газрын барилгын хийц, бүтэц, материал зэрэг нь барилга байгууламжид тавигдах барилга угсралтын болон галын аюулгүй ажиллагааны талаарх норм, дүрэм, стандартын шаардлагыг хангасан байх

		ажиллагааны талаарх норм, дүрэм, стандартын шаардалагыг хангасан байх 7. Нийтийн бие засах газрын тоноглол нь удаан эдэлгээтэй бат бөх /металл/ байх Нийтийн бие засах газрын хаяг, тэмдэг, тэмдэглэл нь сайн харагдахаар гэрэлтдэг будаг, эсхүл цацруулагч бүрхэвчтэй байх 8. Нийтийн бие засах газар нь галын аюулгүй байдлыг хангасан зохион байгуулалттай, галын аюулгүйн дүрэмд нийцсэн гал унтраах анхан шатны хэрэгсэлтэй байх 9. Өрөө тасалгаанд байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, цонхыг барилгын норм, стандартын дагуу хийх 10. Болзошгүй гамшгаас сэргийлж, ослын гэрэлтүүлгийг нарны эрчим хүч ашиглан мэдрэгчтэй гэрэлтүүлэхээр хийх 11. Гаднах орчныг тохижуулах, гэрэлтүүлэг, 2 метрээс өндөр
11	Хяналтын камерын систем	Дуу дүрсний мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник хэрэгсэл байх
12	Халаалт, агаар сэлгэлт, цахилгаан хангамжид тавигдах ерөнхий шаардлага	1. Нийтийн бие засах газрын халаалт, агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж, агаар дамжуулах хоолой, дулаан тусгаарлалтын хийцийг стандартын шаардлага хангасан материалаар хийх 2. Нийтийн ариун цэврийн байгууламжийн агаарын чийгшил, агаарын температурыг стандартын дагуу төлөвлөн хийх 3. Нийтийн бие засах газрын халаах хэрэгсэл болон дамжуулах хоолойн ил хэсгүүдийн гадаргуугийн хэрэгслийг хамгаалах хаалт төлөвлөж, дамжуулах хоолойг дулаалах 4. Гаднах цахилгааны хангамжийг тооцоолон шийдвэрлэх
13	Ашиглалт хамгаалалтын байдал	1. Гүйцэтгэгч тал 3 жилийн хугацаанд эвдрэл гэмтэл, урсгал засварын үйлчилгээг хариуцна.

ХЯНАСАН :
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА 3.ЦЭРЭНДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:
САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА П. НАРАНБААТАР